



157

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1997 оны 5 сарын 16

№ 152

Улаанбаатар хот

**Худалдааны цэг ажиллуу-
лах тухай**

**Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:**

1. Шинээр ажлын байр бий болгох, үйлчилгээний хүрвэг өргөтгөх зорилгоор хотын район, хорооны гүйцэтгэх захиргааны хэргэнд аж ахуйн тооцоотой худалдаа үйлчилгээний цэг зохион байгуулж ажиллуулахыг Хөдөлмөр, эрхлэлтийн газар /н.Энхээ/, район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд даалгасугай.

2. Худалдааны цэгийн асуудлыг Монголын хувийн үйлдвэрийн эздийн холбоо, Хотын Хувийн хөдөлмөр эрхлэгчдийн холбоо, Хоршоолын холбоодтой хамтран үйлчилгээний цэг, салбарыг барьж байгуулах, тохижуулах, түрээсээр ашиглуулах, хэв журам сахдуулах асуудлыг зохион байгуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн газар /н.Энхээ/, Цагдаагийн газар /н.Гаравсүрэн/, район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд даалгасугай.

3. Худалдааны цэг ажиллуулах үлгэрчилсэн журмыг хавсралтын ёсоор баталж, захиргааны алсаны болон, барьж байгуулах, тохижуулах ажилд шаардагдах хөрөнгийг шинээр ажлын байр бий болгох, ажилгүй хүмүүст дэмжлэг үзүүлэх сангаас зөвлөөр санхүүжүүлэхийг Хөдөлмөр эрхлэлтийн газар /н.Энхээ/-т зөвшөөрсугай.

4. Худалдааны цэгийн байршлыг район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаатай хамтран шийдвэрлэхийг Хот байгуулалт, төлөвлөлтийн газар /н.Болд/, Хөдөлмөр эрхлэлтийн газар /н.Энхээ/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА


Л.ЭНЗЭШИ


Ч.СУМААХҮҮ



Улаанбаатар хотын Ардын Хурлын
гүйцэтгэх захиргааны 1991 оны
252-р тогтоолын хувсралт

**ХУДАЛДААНЫ ЦЭГ АЖИЛГУУЛАХ
ҮЛГЭРЧИЛСЭН ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Худалдааны цэгийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь хотын үйлчилгээний хүрээг өргөтгөх, үйлчилгээг иргэдэд ойртуулах, хувийн үйлдвэр, цүүс, хоршоо, бусад үйлдвэр, албан газруудаас илүүдэл бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, түүхий эд, материалаа худалдаж борлуулах ажлыг хөнгөн шуурхай болгох замаар улсад тодорхой хуримтлал оруулж, шинээр ажлын байр бий болгоход оршино.

2. Худалдааны цэгийн захиргаа нь район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд ажиллана.

3. Худалдааны цэгийг санхүүжүүлэх эх үүсвэр нь өөрийн далгуур, лангуу, үйлчилгээний цэг, салбарын түрээсийн болон ашгийн орлого, татвар, торгууль, реклам, сурталчилгаа, зарлал, үйлчилгээ явуулсан патентын орлого, бусад орлого, хангив байж болно. Худалдааны цэг нь аж ахуйн тооцооны зарчим дээр ажиллаж үндсэн ба эргэлтийн хөрөнгө, тусгай сангуудыг байгуулан зарцуулж, ажил үйлчилгээ явуулдаг, бие цаасан баланс, банкинд харилцах ханстай хуулийн этгээд болно.

4. Худалдааны цэг нь оноосон нэртэй, өөрийн алсан бичгийн хуудас, тэмдэгтэй байна.

Хоёр. Худалдааны цэгийн хураг

5. Худалдааны цэг нь НМАУ-ын хууль, тогтоомж, хотын Ардын Хурлын хурал, гүйцэтгэх захиргааны тогтоол, шийдвэрийг удирдлага болгож, энэхүү үлгэрчилсэн журмыг үндэслэн район, хорооныхоо Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд танилцуулсанаар өөрийн зохион байгуулалт, бүтцээ өөрөө бие даан шийдвэрлэнэ.

6. Үйлдвэр, аж ахуйн газар, сум, сангийн аж ахуй, албан байгууллага, хувийн үйлдвэр, цүүс, хоршоод, иргэдээс худалдаж борлуулах зүйлийг тохиромжтой болон улсын үнээр худалдан авч хөдөлмөрчдөд үйлчлэх, өөрийн лангуу байр саваа эцгээр байгууллага, иргэдэд түрээсээр ашиглуулна.

7. Худалдааны цэг нь өөрийн мэдлийн барааг зохих журмын дагуу хөдөө орон нутагт болон гадаадад бараа солилцооны шугамаар зохих журмын дагуу худалдан хөдөлмөрчдийн өргөн хэрэглэний болон хувийн хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, материал, түүхий эд олж котоц нийлүүлэхэд зуучлана.

8. Бараа борлуулалт, гүйлгээ, худалдаа үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар нийслэл хотын хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан сурталчилгаа хийнэ.

9. Хот, дүүргийн хөшөлмөрийн байгууллагатай хамтран ажилгүй, иргэдийг түр хөшөлмөрөөр хангах асуудлыг зохнон байгуулна.

10. Өөрийн үйл ажиллагаатай холбогдоон ажлын мэдээлэл, бүртгэл, тайлан сулалгаа, санал дүгнэлтийг хот, район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд зохих журмын дагуу гарган өгч байна.

11. Өөрийн лангуунд тохиролцооны үнээр авч худалдсан бараа материалын үнийн 8-10 хувийг үйлчилгээний хөлсөнд авна. Үйлчилгээний цэг, салбар, лангуу түрээслэх, хувиараа худалдаа хийгчдийн бараанд татвар тогтоох үнээ өөрөө тогтооно. Хуцалдааны цэг нь өөрийн санхүүгийн үйл ажиллагааныхаа тайлан, мэдээ, татвар, хуримтлал зэрэг асуудлаа дүүргийнхээ санхүүгийн хэлтэст яриуцан тайлаглана.

12. Байцаагч нарын хурааж улсын орлого болгосон барааг "Барааны захир конторын ерөн тос цалингийн санг шинэчлэн батлах тухай" хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 244 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын орлогын барааг худалдаа борлуулах журам"-ын дагуу худалдана.

13. Хуцалдааны цэг нь улс, хормооллын байгууллага, хувийн үйлдвэр, нүүс, иргэдэд зохих журмын дагуу лангуу /вантан/-г олгож үйлчилнэ.

Гурав. Хуцалдааны цэгийн ухироллага

14. Хуцалдааны цэгийн эрхлэгчийг район, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр томилж, ажлаас нь чөлөөлнө. Хуцалдааны цэгийн ажилтан нарыг ажилд томилж, ажлаас чөлөөлөх асуудлыг цэгийн эрхлэгчийн тушаалаар шийдвэрлэнэ.

15. Хуцалдааны цэгийн эрхлэгч нь БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу байгууллагын эд хөрөнгийг зарцуулах, банкинд харилцах данс нээх, албан тушаалтанд итгэмжлэх олгох, байгууллагыг төлөөлж иргэд, албан байгууллагатай харилцан гэрээ хэлцэл хийх, ажилчин албан хаагчийг нагнаж, урамшуулах, сахилга батын арга хэмжээ авах эрхийг эдлэнэ.

16. Хуцалдааны цэгийн ажилтнууд эрхлэгчийн тушаалаар батлагдсан албан тушаалын зааврыг мөрдөн ажиллана.